



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Нийтийн эрх зүйн хуулийн этгээд

2024 оны 10 дүгээр сарын 27 өдөр

Дугаар А/30/24

Улаанбаатар хот

Жуулчны хөтөч-тайлбарлагчид ангилал, зэрэглэл тогтоох
шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг батлах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйл, 26 дугаар зүйлийн 26.1, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн дүрмийн 2 дугаар зүйлийн, 2.2.7 дэх хэсэг, Жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журмын 3 дугаар зүйл 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жуулчны хөтөч-тайлбарлагчид ангилал, зэрэглэл тогтоох шалгалтын комиссыг бүрэлдэхүүнийг дараах байгууллагуудын төлөөлөлтэй есөн гишүүнтэйгээр баталсугай.
 - 1.1. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага - 1 гишүүн,
 - 1.2. Нийслэлийн аялал жуулчлалын газар - 1 гишүүн,
 - 1.3. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ - 2 гишүүн,
 - 1.4. Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо - 1 гишүүн,
 - 1.5. Эрдэмтэн судлаач төлөөлөл - 2 гишүүн,
 - 1.6. Хөтөч-Тайлбарлагч - 2 гишүүн,
2. “Жуулчны хөтөч-тайлбарлагчид үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон мэргэжлийн ур чадварын ангилал, зэрэглэл тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангаж шалгалтын комиссыг даргыг томилж ажиллахыг “Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо” салбар холбоонд даалгасугай.

ДАРГА



Б.ЗОЛБАДРАЛ